

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ХАРИУ ӨГӨХ ЭРХ

Д. Мөнхбүрэн*

* «Глоб интернейшнл» ТББ. Хууль зүйн магистр.

Түлхүүр үг: хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт хэвлэл, үзэл бодлоо илэрхийлэх чөлөө, хариу өгөх эрх.

Чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл буй болсон явдал нь манай улсад олон ургальч үзэл бодлыг төлөвшүүлэх, нийгмийн хурц эмзэг асуудлыг олон нийтэд сөхөн тавьж, нийгмийн бугшмал, хууль бус, далд аливаа ажиллагааг илчлэн, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой хэдий ч зарим тохиолдолд тэдний үйл ажиллагаа нь өөрөө хууль зөрчсөн, хүний халдашгүй баялаг болох нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах, худал хуурмаг мэдээлэл түгээх нь хэвийн үзэгдэл мэт болжээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд хэвлэл мэдээлэл зайлшгүй чухал үүрэгтэй. Хэвлэл мэдээлэл нь засаглалыг ардчилсан нийгэмд нийцүүлж өгдөг гэж үздэг. Олон нийт хэвлэл мэдээллийг хүртэх эрхтэй байх ёстой. Мөн хэвлэл мэдээллээр нэр нь хөндөгдсөн хүнд хэвлэлийн хууль, ёс зүйн журмын дагуу энэхүү мэдээлэлд хариу өгөх боломж олгогддог. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан таатай бус, гэм хор хүргэхүйц байдлаар бичигдсэн мэдээлэл болон шүүмжлэлд өртсөн хэн ч гэсэн

өөрийнхөө байр суурийг илэрхийлэх буюу өөрийнхөө дуу хоолойг гаргах эрхтэй. Үүнийг хариу өгөх эрх гэж нэрлэдэг. Энэхүү эрх нь практикт боломжтой, нийцэмжтэй, шаардлагатай зүйл юм. Иргэдийн хариу өгөх эрх нь Үндсэн хуулиар олгогдсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөөр баталгааждаг.

Жирийн нэг иргэн болон хуулийн этгээдэд олгогдсон энэхүү хариу өгөх эрх нь өөрсдийнх нь тухай бичсэн зүйлд хариулт өгөх эрх юм. Хуульч Жиром Баррон "Хариу өгөх эрхийн үүрэг зорилго бол бүрэн илчлэх, мөн түүнчлэн жинхэнэ ёсоор маргалдаж мэтгэлцэж тухайн асуудлаар үнэлэмжийг авчрах юм" гэж хэлжээ. Энэхүү эрх нь тэрхүү маргаанд хамааралтай нөхцөл байдлыг маш нарийн тодорхойлж, тодруулж чаддаг учраас чухал ач холбогдолтой.

1990-ээд оны үед Австралид урьд жилүүдийнхээс илүү хэвлэл мэдээллийг хүртэх эрх, гүтгэлгийн эсрэг хуулийн ээлжит өөрчлөлтийн талаар хэлэлцэж, маргалдаж эхэлсэн ба олон нийт хэвлэл мэдээллээр нэр төр гутаагдсан хүн тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр залруулга хийлгэх нь мөнгөн төлбөр оногдуулах хариуцлагаас илүү дээр байх эсэх талаар асууцгааж байв. Ингээд

Мельбурний "Herald and Weekly Times" сонин мэргэжлийн ёс зүйн коддоо өөрчлөлт оруулж, хариу өгөх боломжийг анх олгосон байна.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 22 дугаар зүйлд "Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмээс хангамж авах эрхтэй бөгөөд нэр төрөө хамгаалах эрхтэй" гэж хариу өгөх эрхийг Олон Улсын төвшинд тунхаглажээ. Мөн Олон улсын шинжтэй баримт бичгүүдэд хэрхэн тусгагдсаныг үзвэл:

Европын өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн бодлогын асуудлаар сайд нарын хэмжээнд болсон 4-р бага хурлаас хэлэлцэн тохиролцсон Сэтгүүлчдийн эрх чөлөө, хүний эрх гэсэн баримт бичгийн 7-р зарчмын "в"-д:

- үнэн шуларга мэдээлэл, тайлбар, шүүмжлэлийг өгөх бөгөөд хүний хувийн амьдралын тухай худал зүйл мэдээлэх, гүтгэх, үндэслэлгүйгээр буруутгахаас зайлсхийх;

Брюссельд төвтэй Олон Улсын сэтгүүлчдийн холбооны 1954 онд баталж, 1986 онд засварласан Сэтгүүлчдийн баримтлах зарчмын 5-д:

- Аль нэг хэвлэгдсэн зүйл хоруршиг тарихуйц хуудуутай болох нь нотлогдвол түүнийг засч залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийнэ;

Америкийн сонины редакторуудын нийгэмлэгийн үйл ажиллагааны зарчимд:

- Үнэн зөв, мадаггүй байх: Чанартай сайн сэтгүүл зүйн үндэс нь уншигчдийн итгэл хүлээх явдал мөн. Мэдээлэл мадаггүй, агуулгын аливаа гажуудалгүй хийгээд бүх талуудыг адил тэгш гаргасан байхын төлөө сэтгүүлчид бүхий л хүч бололцоогоо дайчлах хэрэгтэй.

Тэргүүн өгүүлэл, редакторын өгүүлэл, задлан шинжилсэн өгүүлэл болон тайлбар өгүүлэл, тойм зэрэг нь мэдээний нэгэн адил баримт сэлтэд хянуур хандсан хэмжээний өндөр төвшинд байх шаардлагатай.

Баримтын алдаа гаргасан буюу баримтыг орхигдуулсан тохиолдолд нэн даруй тод томруунаар залруулах ёстой.

- Булхайгүй тоглох: Мэдээлэлд нэр нь гарч байгаа хүмүүсийн эрхийг хүндэтгэж, нийтээр хүлээн зөвшөөрсөн нэр төрийн хэм хэмжээг са-

хиж, олон нийтийн өмнө мэдээллийнхээ үнэн зөв, мадаггүй байх хариуцлага хүлээнэ.

Ил тод буруушаагдсан хүнд хамгийн богино хугацаанд хариу мэдэгдэл хийх бололцоо олгох ёстой¹.

Австри, Нидерланд, Норвег, Швед, Их Британийн нэгдсэн вант улс зэрэг долоон орны Үндэсний Хэвлэлийн Зөвлөлүүд нь "Хэвлэлийн ажилтны ёс зүй"-г тодорхойлсон бөгөөд түүний 2 дугаарт:

- санал шүүмжлэлд хариу өгөх бололцоог нээх,

«

1990-ээд оны үед Австралид урьд жилүүдийнхээс илүү хэвлэл мэдээллийг хүртэх эрх, гүтгэлгийн эсрэг хуулийн өөрчлөлтийн талаар маргалдаж эхэлсэн ба ХМХ-ээр нэр төр нь гутаагдсан хүн тухайн хэрэгслээр залруулга хийлгэх нь мөнгөн төлбөр оногдуулах хариуцлагаас илүү дээр байх эсэх талаар олон нийт асууцгааж байв. Ингээд Мельбурний "Herald and Weekly Times" сонин мэргэжлийн ёс зүйн коддоо өөрчлөлт оруулж хариу өгөх боломжийг анх олгожээ.

»

"19 дүгээр зүйл" байгууллагаас гаргасан "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба гүтгэлгийн эсрэг хуулийн зарчим"-ын 14 дүгээрт:

- Шүүх боломжийн хэрээр гүтгэлгийн хэрэгт нэр төр гутаагдсаны хохирлыг арилгахад торгуулийн бус аргыг эн тэргүүнд хэрэглэж байх нь зохистой гэж заагаад, үүний зөвлөмж саналд нь: "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахдаа шийтгэх бус, үр дүнтэй байдлаар ашиглана. Хохирлыг барагдуулах торгуулийн бус арга хэрэглэснээр голдуу мэдээллийн чөлөөт урсгал, үзэл санаанд торгуулийн хэлбэртэй харьцуулбал бага хэмжээний сөрөг нөлөөг үзүүлдэг ба хувь хүний нэр төрд учирсан ямар ч хохирлыг арилгахад сайн нөлөөтэй гэж үздэг. Ийм хамгаалалтыг эн тэргүүнд авч байх хэрэгтэй. Хохиролгүй болгох харилцан адилгүй аргыг тухайн шүүн шийдвэрлэж буй хэргээс хамаарч хэрэглэх боломжтой. Эдгээрт уучлал хүсэх, засвар, гүтгэсэн гэдгийг тогтоосон шүүхийн шийдвэр зэргийг дугаартаа гаргах ба хариу өгөх зэрэг багтана" гэжээ.

Хариу өгөх эрхийг зарим улс орнуудад тусгасан нь:

Австралийн Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн 6-р зүйлд:

- Сонин нь хэвлэлтийн алдааны улмаас хор хохирол учруулбал шуурхай бөгөөд хор хохирлын хэмжээг аль болох саармагжуулах няцаалт, залруулга, тайлбар буюу уучлал зэргийн нэр төрийг нь сэргээхэд тохирох арга хэлбэрээр нь хэвлэн нийтлэх мэдээлэлд залруулга хийнэ.

7-р зүйлд:

- Хувь хүн, байгууллага, албан газар болон нийгмийн бүлэг хэсгийн нэр төр, хууль ёсны ашиг сонирхолд гэм хор учруулах материал хэвлэгд-

сэн бол шударга ёсны дагуу хаа ч гэсэн тохиромжтой цаг хугацаанд нь буюу цаг алдахгүй нэр төрөө сэргээх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилготойгоор хариулт буюу няцаалтыг сониноор дамжуулан хийх эрх олгогдоно гэжээ.

Бразилд:

Бүтээлээ буруу ташаа болохыг нарийн тодорхой нотлогдсон үед өөрийнхөө бүтээлд нэр нь дурдагдсан буюу татагдан оролцсон хүмүүст хариу өгөх эрхийг сэтгүүлч хүлээн зөвшөөрөх үүрэгтэй байдаг байна.

Финляндад:

Мэдээлэл нь буруу ташаа, алдаа мадагтай бол сэтгүүлч өөрийн санаачлагаар, эсхүл түүнийг зөвтгүүлэхээр шаардсан этгээд хүсэлт гаргасан аль ч тохиолдолд хугацаа хойшлуулалгүй залруулга хийх ёстой.

Хурцаар шүүмжлэгдсэн этгээд нь энэ хүсэлтээ үндэслэлтэй гаргаж, хариу өгөх эрхээ баталгаажуулах ёстой. Үзэл бодлын ердийн зөрчилдөөний үед хариу өгөх эрх олгох зайлшгүй шаардлагатай биш юм.

Хариу өгөх эрх хүсэх нь цаанаа учир шалтгаантай байвал хариултыг хугацаа хойшлуулахгүйгээр хариулт өгөгч этгээдийн хүссэн хэлбэрээр, тухайлбал уг эх мэдээллийг хүртэгчид буюу олон нийт тухайн хариултыг хялбархан анхаарч ажиглаж ойлгож болох арга хэлбэрээр хэвлэн нийтлэх ёстой.

Хариу нь тохиромжгүй арга хэлбэрээр бичигдсэн бол үүнийг өөрчлүүлэхээр бичигч этгээдтэйгээ хэлэлцэн тохиролцоно. Бичигч нь зохих хугацааны дотор холбоо тогтоож чадаагүй бол хариултыг залруулгын хэлбэрээр хэвлэн нийтлэх нь зүйтэй. Гэсэн хэдий ч түүний үндсэн утга агуулга нь өөрчлөгдөх ёсгүй.

Германы хуулиар:

Редакцийн засвар нь түрүүчийн гаргасан мэдээлэл нь бүхэлдээ буюу зарим хэсэг нь буруу ташаа, алдаатай байсан гэсэн баримт фактад л уншигчдын анхаарлыг татах ёстой. Энэ нь түүнчлэн зөвхөн үнэн зөв баримт фактыг бус, мөн авч хэлэлцэж буй алдаатай буруу мэдээллээсээ ишлэл агуулах ёстой. Алдаатай буруу болох нь олон нийтээр аль хэдийн хүлээн зөвшөөрөгдсөн байлаа ч үнэн зөв баримт фактыг хэвлэн нийтлэх ёстой.

Буруу ташаа мэдээллийг засварлах бол редакцийн хэлтсийн үүрэг юм. Энэхүү үүрэг нь ердөө уншигчдын захидлуудыг цаг хугацаа алдалгүйгээр хэвлэн нийтэлснээр зорилгодоо хүрэхгүй.

Уншигчдын захидалд хэвлэлд нийтлэгдсэн мэдэгдэлд хэвлэлийн тухай хуульд заасны дагуу хариу өгөх эрхтэй гуравдагч этгээдийн талаар баримтаар нотлогдсон шаардлага агуулагддаг.

Гамбургт:

Хариуцлагатай сэтгүүлч, редакци болон тогтмол хэвлэл эрхлэн гаргадаг байгууллагын хэвлэн нийтлэгч нь сөрөг таамаглал болон баримт фактын нотолгоонд хэвлэх байгууллагад хэвлэгдсэн баримт фактын баталгаа нотолгоогоор сэрдэгдсэн хэсэг бүлэг буюу хувь хүний хариуг хэвлэн нийтлэх үүрэг хүлээнэ.

Бие даасан, баримт нотолгоотой алдаа нь цаг алдалгүй шуурхай

бөгөөд бүрэн дүүрэн засан залруулагдах ёстой.

Өгүүлэмж, багана, хянан тохиолдуулалт, толгой, зураг, график, сэтгүүлийн зураг, тайлбар бичиг, нь эндүү ташаа буруу ойлгогдохоор, эсхүл буруугаар гуйвуулахаар байхад нь тодруулга зайлшгүй хэвлэнэ.

Ийнхүү Олон улсын баримт бичгүүдэд болон гадаадын улс орны хэвлэлийн хуулинд иргэдийн хариу өгөх эрхийг баталгаажуулж өгснөөрөө сэтгүүлчдийг хариуцлагатай, ёс

зүйтэй үйл ажиллагаа явуулах эрмэлзэл, иргэдийн нэр төр халдашгүй байх баталгааг бий болгож байна. Тэгвэл манай улсын хувьд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд ийм тусгайлсан заалт байхгүй боловч Монгол Улсын иргэний шинэ хуулийн 21-р зүйлийн 2

«

*Олон улсын баримт бичгүүдэд
болон гадаадын улс орны
хэвлэлийн хуулинд иргэдийн хариу
өгөх эрхийг баталгаажуулж
өгснөөрөө сэтгүүлчдийг
хариуцлагатай, ёс зүйтэйгээр үйл
ажиллагаа явуулах эрмэлзэл,
иргэдийн нэр төр халдашгүй байх
баталгааг бий болгож байна.
Тэгвэл манай улсын хувьд
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний
тухай хуульд ийм тусгайлсан
заалт байхгүй*

»

дахь хэсэгт:

- Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.

Мөн хуулийн 511-р зүйлийн 2 дахь хэсэгт:

- Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн

шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох ба мэдээ тараасан уг хэлбэрээр нь болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно² гэж заасан нь иргэдийн хариу өгөх эрхийг баталгаажуулсан гэж үзэж болох юм. Хариу өгөх эрх нь тухайн этгээд өөрөө өөрийнхөө тайлбар, залруулга, тодруулга, няцаалт зэргийг хийх боломжийг уг хэвлэл мэдээллийн байгууллага нь олгож, түүнийг нь хэвлэн нийтэлж, дамжуулж олон нийтэд хүргэх ёстой бол манай өнөөгийн практикаас харахад тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл маань гомдол гаргагчийн нэрийн өмнөөс өөрийнхөө үзэмжээр "...дугаарт ... гэж буруу ташаа мэдээлснийг залруулж уншина уу..." гэх мэтээр сонинхоо хаа нэг буланд нь хэдхэн үг, өгүүлбэр бичсэн төдий болоод л сониноос залруулга хийчихсэн гэж хариулдаг.

Тэгвэл иргэн, хуулийн этгээд нь өөрийнхөө үйл ажиллагаанд нийцээгүй, буруу ташаа мэдээллийг няцаахыг хэвлэл мэдээллийн редакциас шаардана. Иргэн, хуулийн этгээд нь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн мэдээг хэвлэн нийтэлсэн буюу дамжуулсан уг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан өөрийнхөө хариуг хэвлэн нийтлэх буюу дамжуулах эрхтэй.

Залруулга болон хариу нь тусгайлсан гарчигтайгаар буюу няцаагдаж буй мэдээлэлтэйгээ ижил хуудсанд, ижил шрифтээр хэвлэгдсэн байна. Өдөр тутмын хэвлэлд хэвлэн нийтлэх хугацаа нь тогтмол сонин дараагийн дугаарт гаргаж болно. Няцаалт буюу хариу нь радио буюу телевизээр тэрхүү хөтөлбөрөөр, эсхүл тэрхүү нэвтрүүлгийн дараагийн дугаараар уншигдаж дамжуулагдах ёстой. Хариу буюу няцаалтыг хэвлэн нийтлэхдээ

зайлшгүй редакторлах буюу засаж хасах (тухайн хариу өгөгч иргэн маань мэргэжлийн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан биш тул түүнд мэргэжлийн тусламж хэрэгтэй байж болох юм)-даа түүний утга санааг нь гажуудуулж, утга агуулгад өөрчлөлт хийхийг хориглоно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн хэрэг маргааныг 1999-2001 онд шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн судалгаагаар иргэний нийт 79 хэргийн 47 хэрэгт шүүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруутай гэсэн шийдвэр гаргасан бөгөөд энэ нь нийт иргэний хэргийн 59.4 хувь юм. Харин 29.1 хувь буюу 23 хэрэгт ХМХ нь гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч эвлэрсэн байна³. Хэрэв иргэд нь шүүхийн журмаар биш хариу өгөх эрхийнхээ дагуу няцаалтыг хийлгэсэн бол энэ их цаг алдаж, мөнгө зарахгүйгээр, уг мэдээ нь алдаатай буруу болохыг олон нийтэд хүртээмжтэй түгээснээр илүү үр дүнтэй болох боломжтой юм.

Иргэд хариу өгөх эрхээ сонгодог утгаар нь эдэлснээр худал мэдээлэл түгээж, нэр төр, алдар хүндэд халдсан гэж шүүхэд хандах маргаантай хэргийн тоо эрс багасах боломжтой бөгөөд хариу өгч байгаа этгээдийн хувьд ч энэ нь нэр төрөө хэдэн төгрөгөөр үнэлж хэн нэгнээс авахаас ач холбогдол, үр нөлөөгөөрөө илүүтэй гэдэгтэй санал нэгддэг билээ.

Ишлэл

¹ 2002. Нэр төр, гүтгэлэг. Глоб Интернетшнл ТББ. УБ. Х.127-129.

² 2002. Монгол Улсын иргэний хууль. ХЗДХЯ-ХЗМТ. УБ.

³ 2001. ХМХ-ээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн хэрэг, маргааны талаарх судалгаа. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2003. Б а г е р с т а м Э. Ардчилсан нийгэм дэх хэвлэлийн эрх чөлөө. УБ.
2. 2002. Монгол Улсын иргэний хууль. ХЗДХЯ-ХЗМТ. УБ.
3. 2002. Нэр төр, гүтгэлэг. Глоб Интернетшнл ТББ. УБ.
4. 2001. ХМХ-ээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн хэрэг, маргааны талаарх судалгаа. УБ.

Статья посвящена одному из естественных прав человека демократической формации – праву давать ответы. В эпоху информационного общества это право стало неотъемлемой частью современной цивилизации. Право давать ответы во многих странах мира закреплено и регулируется многочисленными законодательными актами, в том числе и Конституцией. На основании исследования современной практики автор считает, что разрешение споров и жалоб, относящихся к категории унижающих человеческое достоинство, порочащих честь и репутацию и т. п., не традиционным путём через обращение в суд, а утилизацией права давать ответы, то ситуация в Монголии коренным образом изменилась бы к лучшему.